МОНГОЛ УЛС, БНСВУ-ЫН ХООРОНД ИРГЭН, ГЭР БҮЛИЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ БАТЛАМЖ ЖУУХ БИЧГҮҮДИЙГ СОЛИЛЦСОН ТУХАЙ ПРОТОКОЛ

Монгол Улсаас БНСВУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ноён Агваандорж Цолмон,

БНСВУ-ын Гадаад хэргийн дэд сайд Ноён Ле Ван Банг нар

Улаанбаатар хотноо 2000 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан "Монгол улс, БНСВУ-ын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээ"-ний Батламж жуух бичгүүдийг 2002 оны 5 дугаар сарын 14-ний өдөр солилцов.

Хоёр тал дээр дурдсан Батламж жуух бичгүүд нь зохих журмын дагуу бүрэн гүйцэт үйлдэгдсэн болохыг шалгаж тогтоов.

Дээр дурдсан Гэрээний 76 дугаар зүйлийн заалтын дагуу энэхүү Гэрээ нь Батламж жуух бичгүүдийг солилцсон өдрөөс 30 хоногийн дараа буюу 2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болно.

Үүнийг нотолж дор гарын үсэг зурагсад энэхүү Протоколыг байгуулав.

Энэхүү Протоколыг Ханой хотноо 2002 оны 5 дугаар сарын 14-ний өдөр монгол, вьетнам хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Монгол Улсын
нэрийн өмнөөс

Онц бөгөөд
Бүрэн эрхт элчин сайд
Агваандорж Цолмон

БНСВУ-ын
нэрийн өмнөөс

Гадаад хэргийн
дэд сайд
Ле Ван Банг